



XXI ЗУУНЫ МАЛЧИН

МОДУЛЬ 4

ӨВСНИЙ СОРГОГ, УСНЫ ТУНГАЛАГ



Хөдөө Аж Ахуйн
Үйлдвэрлэлд Шинжлэх
Ухааны Ололт Нэвтрүүлэх Төв




Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага

XXI ЗУУНЫ МАЛЧИН

МОДУЛЬ 4. ӨВСНИЙ СОРГОГ, УСНЫ ТУНГАЛАГ



УЛААНБААТАР
2013



ТАНИХ ТЭМДЭГ



Уншаарай



Анхаараарай



Хамтран ажиллаарай



Хүүхэдтэйгээ ярилцаарай



Өөрийгөө үнэлээрэй



Бичээрэй

Модуль 4. ӨВСНИЙ СОРГОГ, УСНЫ ТУНГАЛАГ

Боловсруулсан:

Д.Гүндэгмаа

Хянан тохиолдуулсан:

И.Ханымхан, Ч.Нилбаатар, Н.Монголмаа

Зураач:

Г.Амарсанаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн: Н.Эрдэнэ



© 2013. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага

АГУУЛГА

1. Удиртгал 5
2. Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээр 8
3. Бэлчээрийг зохистой ашиглах арга..... 20
4. Бэлчээр, хадлангийн талбайг тордож сайжруулах арга 26
5. Ашигласан материал 36

МОДУЛЬ 4. ӨВСНИЙ СОРГОГ, УСНЫ ТУНГАЛАГ

Зорилго: Бэлчээрийг зөв ашиглах, нөхөн сэргээх мэдлэг, чадвар эзэмшиж, байгаль орчноо хайрлан хамгаалах хандлага төлөвшихөд тусална.


Энэхүү модулийг үзэх явцад Та:

- Бэлчээрийн төрлийг ялгах,
- Бэлчээрийн даац, ургацыг тодорхойлох,
- Нутаг бэлчээрийг зөв хуваарьтай ашиглах, сэлгээ хийх,
- Энгийн аргаар бэлчээр, хадлангийн талбайг сайжруулах,
- Бэлчээр ашиглах, тэжээлийн ургамал тариалахад ашиглах тоног төхөөрөмжийг аюулгүй зөв ашиглах,
- Бэлчээр ашиглах талаар олсон мэдээлэл, амжилтаа бусадтай хуваалцах мэдлэг, чадвар эзэмшинэ




1, Асуултад хариулаарай.

Асуулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.Бэлчээрийнхээ ургацыг тодорхойлж чадах уу?	★	○	△
2.Бэлчээрийнхээ даацыг тодорхойлж чадах уу ?	★	○	△
3.Бэлчээрийг зөв зохистой ашиглах аргын талаар мэдэх үү?	★	○	△
4.Малынхаа тоог хонин толгойд шилжүүлж чадах уу?	★	○	△
5.Бэлчээрийнхээ өвс ургамлын талаар сайн мэдэх үү?	★	○	△
6.Бэлчээрийн уст цэгийг тодорхойлж, худаг гаргаж чадах уу?	★	○	△
7.Бэлчээрийн талхлагдал, цөлжилтийн талаар мэдэх үү?	★	○	△
8.Бэлчээрийг тордож сайжруулах аргыг мэдэх үү?	★	○	△
9.Танай бэлчээрийг тордож сайжруулах шаардлагатай юу?	★	○	△
10.Бэлчээрийг юугаар борддог вэ?	★	○	△



2. Тухайн дүрсийг хэдэн удаа сонгосноо доод талын дөрвөлжинд тоогоор бичээрэй.

Хэрвээ та ☆-г 6 удаа сонгосон бол түүний доод талын дөрвөлжинд **6** гэх мэтээр тэмдэглээрэй.



Санамж

- ☆ 6-8 байвал, Та бэлчээр ашиглах, хамгаалах, тордож сайжруулах талаар туршлагатай, гэхдээ мэдлэг, туршлагаа баяжуулах шаардлагатай байна гэж үзнэ.
- 4-6 бол Та бэлчээр ашиглах, хамгаалах, тордож сайжруулах талаар мэдлэг туршлага багатай энэ талаар их зүйл сурах шаардлагатай байна.
- △ 2-4 байвал, бэлчээр бол малчин хүний тухайд юугаар ч сольшгүй, алт мөнгөнөөс ч илүү чухал баялаг учраас та түүнийгээ зөв зохистой ашиглах, хайрлан хамгаалах талаар шамдан суралцаарай гэж зөвлөж байна

1. УДИРТГАЛ



Ганаа, Болороо хоёр Адиад шавь ороод, их юм сурч байгаадаа баяртай байх болов.

Адиа дараагийн хичээлд ирэхдээ ургамлын цуглуулгаа авч ирээрэй гэсэн болохоор тэд зунжингаа цуглуулсан ургамлуудаа тусгай зургийн цомогт нямбайлан хийж бичсэн тайлбарыг дахин нягтлан уншив. Батаа хүүгийнхээ будсан “Яргуй” цэцгийн зургийг цуглуулагтаа бас хийв.

- Даалгавраа хийхдээ хүүхдүүдээ яаж оролцуулсан бэ? гэж Адиа дандаа асуудаж гэнэ.

Ганаа, Болороо хоёрын цуглуулсан ургамлууд



БУТУУЛ - Бутуул аль ч улиралд хонь, ямаа, адуунд гойд сайн тохирох бөгөөд үхэр ч дуртай иддэг. Түүнчлэн зун намрын улиралд бутуул ихтэй бэлчээрт мал махан болон өөхөн тарга сайн авна.



СОГООВОР - Ногоон байх үед нь үхэр гойд сайн, адуу, хонь, ямаа дажгүй иддэг. Согоовор хатах үедээ нилээд модорхог болж хатуурдаг учир хатсан үед нь мал төдийлэн сайн иддэггүй.



ДААГАН СҮҮЛ - Ногоон байхад нь тэмээнээс бусад бүх мал маш дуртай иддэг. Харин хагдрах үедээ моджиж хатуурдагаас бүх төрлийн мал бага зэрэг л иддэг.



МОНГОЛ ӨВС - жилийн аль ч улиралд бүх төрлийн малд сохимжтой. Зун монгол өвс элбэгтэй бэлчээрт оторлосон мал сайн таргалдаг.

=



ДЭРСЭН ХОР - Хавар эрт ургадаг учир өвс, ногоо ховор, хавар цагт мал идэж хордох нь олонтой байдаг юм.



МӨНХ ХАРГАНА - бэлчээрийн өвс ургамал ховордсон үед тэмээ, хонь, ямаа заримдаа үхэр хүртэл идэж хордоно. Их хортой ургамал



-Эрдэмтэд биднийг ургамал судлаач гэж үзэж байгаа нь зөв байна шүү, хө, тийм ээ?



-Юу гэж байгаа юм. Хэдэн жилийн дараа би Намхайнямбуу баатар шиг ном бичнэ.

-Юу гэж үзэх нь чухал биш. Хэдэн малдаа хортой ургамал идүүлчихгүй байхыг мэддэг байвал л болох нь тэр.



Өргөн хангай нутаг минь
Ургац бэлчээрээр арвин юм ...

Ганаа даалгавраа шалгуулаад, дараагийнхаа модулийг авч ирэхээр дуу аялан гарч одов





2.НАРИЙН ӨВС УРГАСАН МАЛЫН САЙХАН БЭЛЧЭЭР

Нарийн өвс ургасан малын сайхан бэлчээртэй

Нааш цааш сүлжих тэнэгэр сайхан нуруутай

Дөрвөн цагийн улиралд дураараа нүүх нутагтай

Таван зүйлийн тарианы хөрс шороот газартай

Энэ бол миний төрсөн нутаг
Монголын сайхан орон



Бэлчээр. Мал болон өвсөн тэжээлт амьтдын тэжээлийн хэрэгцээг хангахуйц идэмж бүхий ургамалтай, тэжээлийн нөөцтэй газар нутгийг бэлчээр гэдэг. Бэлчээрийг хангайн, хээр талын, говийн хэмээн бүсчилдэг.



Малын бэлчээрийн **хангайн бүсэд** Монгол улсын хойд хэсэг, Алтайн нурууны зарим салбар, Хянганы нурууны үргэлжлэл болон Халх гол орчмын уулархаг газар хамрагдах ба нийт нутгийн гуравны нэг орчим хувийг эзэлнэ. Бэлчээрийн гол ургамал нь үет ургамал.



Үет ургамлын дийлэнхи нь бутуул, ерхөг, дааган сүүл, шивээт хялгана, хиаг, голын хиаг, хазаар өвс, биелэг, сибирийн өлөнгө зэрэг юм. Хангайн бүсийн үет ургамлууд ерөнхийдөө шимт чанараар сайн бөгөөд тэмээнээс бусад төрлийн малд ямар ч улиралд тохиромжтой. Гэхдээ бутуул, хазаар өвс мэтийн богино тачир ургадаг үет ургамал хонь, адуу, ямаанд илүү тохиромжтой байхад согоовор, сибирийн өлөнгө зэрэг ургамал үхэрт илүү тохиромжтой. Хангайд бутуул, ерхөг, хиаг, дааган сүүл зэрэг ургамал ихтэй бэлчээрийг малчид өндөр үнэлдэг юм. **Малын бэлчээрийн хээр талын бүс** нь хангай, говийн хооронд өргөн уудам нутгийг эзлэн орших бөгөөд тэнд хонь, адуу, үхэр сүргийг үржүүлнэ. Малын бэлчээрийн гурван бүсийн дотроос хамгийн олон адуун сүрэг байршсан бүс юм.





Хээр талын бэлчээрт шивээт хялгана, хазаар өвс, хиаг, ерхөг, монгол өвс, дэрс, дааган сүүл зэрэг үет ургамал элбэг ургах боловч бэлчээрийн бараг тэн хагасыг үет ургамал эзэлдэг. Хээр талын бүс нь хуурайдуу уур амьсгалтай, хөрсний чанар нь хангайн бүсээс муу, бэлчээрийн ургац нь намхан тачир, сийрэг боловч шимт чанараараа хангайн ургамлаас илүү байдаг.


Малын бэлчээрийн **говийн бүс** нь хээр талын бүсээс урагших уудам их нутгийг бүхэлд нь хамардаг. Говийн бүсийг заримдаг цөл ба цөл гэж хуваадаг. Тэнд тэмээ, хонь, ямаа, адууг үржүүлэх бөгөөд үхэр сүрэг харьцангуй цөөн байдаг.



Говийн бүсийн бэлчээрт монгол өвс зонхилох ба хужирлаг ургамал болох бударгана, багалуур, таана, олон төрлийн шаваг, шарилж ч нилээд ургана. Хужирлаг ургамал-монгол өвст бэлчээр нь шимт чанар сайтай ургамлаар баялаг учир малчид, түүнийг ямарч улиралд малд тохиромжтой бэлчээр гэж үздэг.

Малын жилийн хэрэгцээт тэжээлийн **98** хувийг хангаж байгаа бэлчээрийн ургац өвөл, хаврын улиралд **50-70 хувь** хүртэл, ургамлын шимт чанар **70-80 хувиар** буурдаг. Үүнээс үүдэн мал тарга хүчээ алдаж, өлдөж үхэхэд ч хүрдэг. Иймээс малчин хүн бэлчээрээ зүй зохистой ашиглах, тордох, сайжруулах талаар мэддэг, санаа тавьдаг, хэрэгжүүлдэг байх ёстой.

Бэлчээрийн талбайг тодорхойлох арга. Ашиглаж байгаа бэлчээрийн урт, өргөнийг км-ээр баримжаалан хооронд нь үржүүлж талбайн хэмжээг тогтооно. Жишээ нь: Нарийн хөндийн бэлчээрийн өргөн 4 км, урт нь 5 км бол $4 \text{ км} \times 5 \text{ км} = 20$ ам дөрвөлжин км гарна. 1 ам дөрвөлжин км нь 100 га-тай дүйцдэг. Тэгвэл $20 \times 100 \text{ га} = 2000$ га гэх мэтээр бодно.





-За цааш нь Болороотойгоо хамтраад бэлчээртэй холбоотой даалгавруудыг хийгээрэй. Хүүхдүүдээ оролцуулахаа мартуузай.

-“Цэцэг сайн будсан байна. Дахиад олныг будаж бай. Адиа нь очихдоо үзээд сайн будсан байвал шагнана шүү” гэж байна гэж Батаа, Булгаа хоёрт хэлээрэй.

- Айлынхаа Болд, Урна хоёрт Болороо та хоёр дамжуулж заа. Нүүрний тос, саван мэтийг “сүлжээ”-гээр орон даяар түгээгээд байхад, мал маллах ухааныг тийм аргаар яагаад түгээж болохгүй гэж, хө. Хүнд заавал сурсан юм их сайн тогтдог юм.



-Тэгье. Тэр хоёр их сонирхоод байгаа юм.



Дасгал 1. Бэлчээрийнхээ ургацыг дараах аргачлалын дагуу тодорхойлоорой

а. Эхлээд бэлтгэлээ хангаарай

- Туузан метр
- Хайч
- Тооны машин
- Жин хэмжигч



б. Бэлчээрээсээ ургац нь янз бүр 5 хэсэг газар сонгон авч, хааш хаашаа 1 м хэмжээтэй модон хашлагаар хашаарай



в. Хашлага дотор байгаа бүх ургамлыг газрын хөрснөөс дээш 2-3 хуруу өндөрт хайчлан авч уутанд хийгээрэй


г. Ууттай ургамлаа жигнээрэй



д. Сонгосон 5 газрын ургамлыг бүгдийг хайчилж жигнээд хүснэгтэд тэмдэглээд бодож тооцоорой. Жишээ нь:

	Ургац, грамм
I	50
II	70
III	80
IV	40
V	60
Нийлбэр	300
Дундаж	60
Ургац, кг/га	600 кг/га

1. Нийлбэрийг олно.
$50 + 70 + 80 + 40 + 60 = 300$
2. Дунджийг олно.
$300 : 5 = 60$
3. 10000-аар үржүүлнэ.
$60 \times 10000 = 600000$
4. Килограммд шилжүүлнэ.
$600000 : 1000 = 600$





-Яагаад 10000-аар үржүүлэх ёстой билээ, хө?



-Яахав дээ... 1 га-д 10000 ам метр байна биз дээ?



Бэлчээрийн даац тодорхойлох аргын талаар эрдэмтдийн зөвлөгөөг уншаад бэлчээрийнхээ даацыг тодорхойлоорой.

Б.Минжигдорж, М.Найданхүү, Г.Наранцэцэг нар. Бэлчээрийн даац гэдэг нь 1 га газрын бэлчээрийг тодорхой хугацаанд ашиглах малын тоогоор илэрхийлэгдэнэ. Байнгын эзэмшлийн буюу ашиглаж байгаа бэлчээрийг улирал, сар, өдрөөр хуваарилж эдлэхийн тулд өрхийн болон хот айлынхаа бүх малыг хонин толгойд шилжүүлж шаардагдах талбайг тооцно. Тэгэхдээ нэг адууг 7, тэмээг 5, үхрийг 6, ямааг 0.9 гэж шилжүүлнэ. Нийт малдаа өдөрт шаардагдах бэлчээрийн талбайг дараах аргаар тооцно:

$$T = \frac{\theta_x \cdot X_x \cdot C}{(Y \cdot K) : 100} = \frac{2 \cdot 110 \cdot 700}{(600 \cdot 60) : 100} = 428 \text{ га}$$

T - өдөрт шаардагдах бэлчээрийн талбай /га/

θ_x – нэг хонь өдөрт идэх өвсний хэмжээ (2 кг)

X_x – бэлчээрлүүлэх хугацаа (110 хоног)

C – нийт хонин толгойн тоо (700)


Y – га бэлчээрийн ургац (6 ц)

K – бэлчээр ашиглалтын түвшин (60%)

700 хонин толгойг 110 хоног бэлчээрлэхэд 428 га талбай шаардлагатай.

Нэг хонин толгойн өдөрт идэх өвсний хэмжээг тооцохдоо:

$$\theta_x = \frac{H \cdot Ц}{100} = \frac{2 \cdot 14}{100} = 0,28 \text{ ц/тол}$$



Өх - өвсний хэмжээ

Н – хоногт идэх өвс (2 кг)

Ц – бэлчээрлэх цаг (14)

Нэг хонинд 14 цагт 2.8 кг, 700 хонинд 1960 кг өвс шаардлагатай. Дээрх тооцоог үндэслэн 6 ц ургацтай 100 га бэлчээрт хэчнээн хонь байх даац багтаамжийг тооцохдоо:

$$БД = \frac{У \cdot К \cdot 100}{Өх} = \frac{6 \cdot 60 \cdot 100}{19,6} = 1837$$

У – малд идэгдэх бодит ургац

К – бэлчээр ашиглалтын түвшин

Өх – өдөрт идэх өвс

100 га бэлчээрт 1837 хонь багтах даацтай гэж үзнэ.

$$Т = \frac{Ө_x \cdot X_x \cdot С}{(У \cdot К) : 100} = \frac{2 \cdot 110 \cdot 700}{(600 \cdot 60) : 100} = 428 \text{ га}$$


Эрдэмтний зөвлөгөө

Ү.Аварзэд, Т.Содной нар. Ямар ямар төрлийн хэчнээн малыг ямар улиралд, ямар хугацаагаар бэлчээрлүүлэхэд хүрэлцэх, эс хүрэлцэх байдлын үнэлгээ тооцоог бэлчээрийн даац гэж ойлгоно. Тухайн жилд хур бороо ахиухан ороод өвс ургамал сайн ургасан нутагт даац нь нэмэгдэнэ. Гандуу буюу гантай жилд бол багасна... Бэлчээрийн ургац сайн боловч ашиглалт буруу байвал бэлчээрийн даац багасч дутагдана. Зөв сайн ашиглавал бараг боломжгүй байдалтай багахан талбайтай бэлчээр байсан ч бас болоод л байна. Үнэхээр нийт бэлчээрийн талбай нь хүрэлцээгүй байвал бэлчээж ашиглах малаа цөөрүүлэх, шинэ нутаг бэлчээр сонгох, отор нүүдэл хийж цаг хугацаа хоног хожиж бэлчээрээ гамнах шаардлага гарна. Ядахдаа бэлчээрээ маш нарийн арга ухаанаар ариг гамтай ашиглах хэрэгтэй болно.



Дасгал 2. Зураг 1-ийг ашиглан, өрхийнхөө малын тоог хонин толгойд шилжүүлээрэй. Санамж: Хэрэв танайх 6 тэмээтэй бол 6-аар үржүүлээд хонин толгойд шилжүүлсэн нь 36 болно.





Зураг 1. Малын тоог хонин толгойд шилжүүлэх нь

* * *

- Ганаа, үхрээ хонин толгойд шилжүүлье. Тугал, бяруугаа бас л 6-аар үржүүлэх юм байх даа?
- Тугал, бяруу ч гэсэн үхэр юм чинь тэгэх байлгүй



- Ээж ээ, аав аа, та хоёр юу бодоод байгаа юм бэ? Би бас тооны машинаар тоо бодож сурмаар байна.

Тийм үү, ээж нь заагаад өгөх үү?

- За тэг

- Эхлээд тоо мэддэг болох хэрэгтэй



1

Энэ бол нэгийн тоо

2

Энэ - хоёрын тоо

3

Энэ - гурвын тоо. Сайн хараад нүдлээд ав.



- За одоо 1-ийн тоо тооны машин дээр байна уу, ол доо. Батаа хэсэг харснаа 1-ийн тоог машин дээр олж заав. Дараа нь 2, 3-ын тоог олов.
- Сайн байна. Миний хүү тоо сайн мэддэг болохын тулд дараах тоог ээжийнхээ зааснаар хуруугаараа дагуулан зур. Болороо хүүгийнхээ гарыг барьж, хуруугаар нь хэд дахин зуруулав. Хаанаас нь эхэлж зураад, хаана нь дуусгаж байгааг сайн хэлж өгөв. Дараа нь Батаа өөрөө хэд хэд зурав, тэгээд 1, 2, 3-ын тоог будав. Болороо хүүгийнхээ будсан тоонуудыг гэрийнхээ хоймор, баруун, зүүн талын хөшгөнд нэг нэгээр нь тогтоогоод "Миний хүү жаахан байж байгаад л будсан тоонуудаа хараад нүдлээд байгаарай. Хэдийн тоо болохыг мартсан бол ээжээсээ асуугаарай" гэв.

1

2

3

Эрдэмтний зөвлөгөө .


Минжигдорж нар. Бэлчээрийн даацыг дутуу ашиглавал мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл багасдаг, даацыг хэтрүүлбэл бэлчээрийг доройтолд оруулдаг муу талтай. Бэлчээрийн даацыг тохируулахад дараахь аргуудыг хэрэглэж болно. Үүнд:

- Алс зайдуу, тогтмол ашигладаггүй нутаг бэлчээрийг отроор ашиглах,
- Даацаас хэтэрсэн малаа зарж борлуулах,
- Хадлан тэжээлийн нөөц бий болгох,
- Адууг өвөл алсын оторт 120-150 хоног гаргах,
- Малын үүлдэр угсааг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэн эрчимжсэн мал аж ахуйг эрхлэн хөгжүүлэх гэх мэт.

Бэлчээрийг зохистой ашиглах хэд хэдэн аргууд байдаг. Үүнд:

- Бэлчээрийн сэлгээ хийх, өнжөөх, амрах,
- Байгалийн бэлчээрийг сайжруулах арга хэрэглэх,
- Таримал хадлан бэлчээр бий болгох зэрэг болно.

Бэлчээрийн талхагдал гэж юу вэ?



Бэлчээрийг буруу ашигласнаас хөрс усны горим алдагдаж, тэжээлийн ургамлууд нь тачир сийрэг болж ургац нь буурах үзэгдлийг бэлчээрийн талхагдал гэдэг.

Бэлчээр яагаад талхагддаг вэ?

Даац хэтрүүлэн ашиглах,

- Сэлгээгүй ашиглах,
- Цөлжилт,
- Нөхөн сэргээлтгүй уул уурхай зэрэг нь бэлчээр талхагдлын шалтгаан юм.

Бэлчээр талхагдлыг **бага, дунд зэрэг, их талхагдлын** үеүүдээр авч үздэг. Жишээ нь, худаг уст цэгээс 1 км орчимд их талхагдалтай байхад, 10 км-т бага талхагдалтай байдаг.

Бэлчээрийн талхагдлыг илэрхийлэгч ургамлууд. Бэлчээрийн **хээрийн бэлчээрт** хиаг, навтуул, агь, өмхий шарилж, нугын бэлчээрт багваахай, ширэг улалж, галуун гичгэнэ, **говийн бэлчээрт** хэрлэг өмхий өвс, лууль бэлчээрийн талхагдлыг илэрхийлэгч ургамлууд юм.

Дасгал 3. Бэлчээрийн бүртгэлийн хуудсыг зааврын дагуу бөглөөрэй.

Бэлчээрийн бүртгэлийн хуудас

1	Улирал	Зун	Намар	Өвөл	Хавар
2	Газрын нэр				
3	Зонхилох ургамлын нэр				



4	Талбай, га				
5	Даац, хонин толгой				
6	Талхагдсан эсэх				
7	Талхагдлыг илэрхийлэгч ургамлын нэр				
8	Сэлгэж ашигласан эсэх				

ЗААВАР:

Бэлчээрийн бүртгэлийн хуудсыг дараах зааврын дагуу бичээрэй. Үүнд:

1. Газрын нэр: Зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржааныхаа нутаг бэлчээрийнхээ нэрийг,
2. Зонхилох ургамлын нэр: Өөрийн бэлчээрт элбэг ургаж буй 1-2 ургамлын нэрийг,
3. Бэлчээрийн талбай (га): Зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржааныхаа нутаг бэлчээрийнхээ хэмжээг,
4. Даац: Бүх малынхаа тоон хонин толгойд шилжүүлэн бодсон даацыг,
5. Талхагдал: Бэлчээр нутаг талхагдсан эсэх, талхагдсан бол ямар үе шатандаа байгааг,
6. Талхагдлыг илэрхийлэгч ургамлын нэр: Талхагдлыг илэрхийлэгч ургамал танай бэлчээрт ховордож байгаа эсэх талаар,
7. Сэлгээ: бэлчээр нутгаа сэлгэж ашигласан эсэхээ бич тус тус бичээрэй.







Өөрийгөө үнэлээрэй.

1. Асуултад хариулаарай.

Асуулт	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1. Бэлчээрийнхээ өвс ургамлын талаар сайн мэдлэг болж байна уу?	★	○	△
2. Монгол орныхоо малын бэлчээрийн бүсчлэлийн талаар мэддэг болсон уу?	★	○	△
3. Бэлчээрийн өвсөнд мөнгөн үнэлэмж тогтоож чадах уу?	★	○	△
4. Бэлчээрийнхээ ургацыг тодорхойлж чадах уу?	★	○	△
5. Бэлчээрийнхээ талбайг тодорхойлж чадах уу?	★	○	△
6. Малаа хонин толгойд шилжүүлж чадах уу?	★	○	△
7. Бэлчээрийнхээ даацыг тодорхойлж чадах уу ?	★	○	△
8. Хүүхдэдээ цифр(тоо) нүдлүүлэх арга мэдэх үү?	★	○	△

2. Тухайн дүрсийг хэдэн удаа сонгосноо доод талын дөрвөлжинд тоогоор бичээрэй.

Хэрвээ та ★-г 6 удаа сонгосон бол түүний доод талын дөрвөлжинд **6** гэх мэтээр тэмдэглээрэй.



Санамж

★ 6-8 байвал, Та энэ модулийг үзэж эхлэхэд мэдэхгүй байсан зүйлээ мэддэг, чаддаг болж байна. Баяр хүргэе!

○ 4-6 бол Таныг зүтгэл гарган суралцаж байгаад баяр хүргэе! Гэхдээ та улам хичээн суралцах хэрэгтэй шүү.

△ 2-4 байвал, бэлчээр бол малчин хүний тухайд юугаар ч сольшгүй, алт мөнгөнөөс ч илүү чухал баялаг учраас та түүнийгээ зөв зохистой ашиглах, хайрлан хамгаалах талаар шамдан суралцаарай гэсэн зөвлөгөөг давтан хэлж байна.



3.БЭЛЧЭЭРИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ АРГА



Монгол малчид бэлчээрээ улирлын байдлаар 4 хэсэгт хуваарилж байнгын нүүдэл, суудал хийж ашиглаж ирсэн уламжлалтай. Энэ нь нэг талаас бэлчээр нутгаа хамгаалах, нөгөө талаас малаа эрсдэлээс хамгаалах нэг арга юм.



Зураг1. Бэлчээрийг улирлаар ашиглах хуваарь

Тухайн нутгийн бэлчээрийг яаж ашиглахыг тэр нутаг, гол, багийн малчид хамтын ухаанаар шийдэх хэрэгтэй юм. Үүний тулд тухайн нутаг, баг, сумын малчдын хурлаар бэлчээрээ хэрхэн ашиглах талаар хэлэлцэж хамтын шийдвэр гаргах, түүнд сумын засаг даргын тамгын газрын хариуцлагатай ажилтан, засаг дарга, иргэд оролцулах, зураглал график, төлөвлөгөө, тогтоол захирамж гаргуулан, төрийн захиргааны эрхийн актаар баталгаажуулах, зөрчил гаргагчдад хариуцлага тооцох зэргээр бэлчээрээ хамтаараа хамгаалж ашиглаж байх нь онц чухал юм. Малчдад дэвсгэр нутгийнхаа хадлан бэлчээрийг хамгаалахаас илүү эрхэм чухал ажил үүрэг байхгүй. Яагаад гэвэл хадлан бэлчээр бол юугаар ч сольшгүй, үнэт капитал, алт мөнгөнөөс ч илүү чухал баялаг юм.

* * *

Ганаагийн багийнхан хурлаараа бэлчээр ашиглалтын талаар хэлэлцээд, дараа нь овоо тахив. Багийн хуралд сумын Мал эмнэлэг-үржлийн тасгийн мэргэжилтнүүд, засаг даргын тамгын газрын ажилтан нар оролцов.

Бэлчээр ашиглах тухай журамд малчдын саналыг тусган өөрчлөөд сумын засаг даргын тамгын газраар батлуулан, өрх бүр мөрдөх шийдвэр гаргалаа.






Эрдэмтний зөвлөгөө

Ү.Аварзэд, Т.Содной нар. Бэлчээрийн хуваарийг жил жилийн байдлаар шинэчлэх шаардлагатай. Ер нь малын төрлийн харьцаа хэтэрхий алдагдвал бас асуудал гарна. Тухайлбал, ямаа хэт олширвол бэлчээрийн өвс ургамал нөхөн сэргэж ургахгүй болж цөлжилтийн гай гамшиг ч учрах талтай. Зарим улс оронд ямаа хэт өсөөд ийм аюулд учирч байсан гашуун түүх ч байдаг байна. Энэ бүхнийг эргэцүүлэн ухаарч, бэлчээрээ зөв зохистой ашиглах, хамгаалах талаар багагүй ухаан зарж ажиллах ёстой юм. Хэзээнээс өвөг дээдэс маань, ялангуяа, хүйтэн сэрүүн хангай нутагт ямааны тоог хониныхоо 20-30 хувиас хэтрүүлдэггүй байжээ...


Бэлчээрийн аль амт шимтэй ургамлыг ямаа шөвгөр туруугаараа шигтгэн гишгэж, мөн үндсийг нь ухаж мэргэ идэх зэргээр нөхөн ургахгүй болгон сүйтгэдэг...

Хүйтний улиралд бэлчээр ашиглах арга. Өвөлжөөнд буусны дараа цас хамгийн их унаж хөрлөдөг, алсын бэлчээрийг эхэлж ашиглана. Малын хээл хүндрээгүй үед өгсөж хотлохоор, хээл томроход уруудаж ирэхээр малынхаа хээлийн байдалд тохируулан бэлчээрээ ашиглахаар бодож тооцоолно. Нөмөртэй өвс сайтай бэлчээрээ мал төллөх буюу хүйтэн салхи шуургатай үед ашиглахаар нөөцлөнө.

Цас их унаснаас өвөлжөө, хаваржааны бэлчээрт цас хунгарлан зузаарч өвс ургамал цасанд дарагдсанаас мал бэлчих бололцоогүй болох явдал тохиолдоно. Цас ихэдсэн үед бэлчээрийн цасыг арилгаж ашиглах хэрэгтэй. Үүнд: Өвөлжөө, хаваржаанаас



бэлчээр хүртэлх замын хөр зузаан цасыг арилгаж юуны өмнө зам гаргана. Дараа нь бэлчээрийг мал бэлчих боломжтой болгоно. Харин өдөр өдөрт нь ашиглах бэлчээрийн цасыг арилгаж байх нь зохимжтой. Малаа бэлчээхээс хэд хоногийн өмнө бэлчээрийн цасыг арилгавал өнгөн дээрх цас хөлдөж малын хөл, хушууг халцалж арьсыг гэмтээдэг муу талтай. Бэлчээрийн цасыг арилгахын тулд адуу, үхэр тууж зам гаргах, төмөр, банз, дүнзээр хийж дальпуу /цас ярагч/ трактор буюу бод малаар чирч цасыг зайлуулна. Мөн хүрз, гапуугаар хэд хэдэн хэсэгт гэрийн буйрын чинээ газрын цасыг цэвэрлэж малыг цөөн цөөнөөр нь хэсэглэн идүүлнэ.




Зураг 2. Өвлийн бэлчээрийг ашиглах хуваарь

Дулааны улиралд бэлчээр ашиглах арга. Дулааны улиралд бэлчээр ашиглах үндсэн зорилго нь бэлчээрээ доройтуулахгүйгээр малдаа аль болох шимт чанар сайтай ногоо идүүлж дээд зэргийн тарга хүч авахуулахад чиглэгдэх ёстой.


Бэлчээрийн ургамлыг дулааны улиралд 2-3 удаа хэнзлүүлэн ашиглах боломжтой. Үүний тулд дулааны улиралд /зусланд/ буусан бэлчээрээ 6-7 зурваст хувааж нэг зурваст 4-5 хоног хариулах замаар нэг сар буюу 30 хоногийн дараа анх ашигласан ургамал хэнзлэн ургаж дахин ашиглах хэмжээнд хүрдэг. Ингэж ашиглах гол арга нь бэлчээрт хотлуулах отрын арга юм.

Бэлчээрийн ургамлын хэнзлэх хугацаанд нь тохируулан давтан ашиглах нь олон талын ач холбогдолтой. Үүнд:

- Бэлчээрийн ургамал нөхөн сэргэх боломжтой болох,
- Ургамал хэнзлэх нөхцөл бүрдэх,



- Холын нүүдэл хийх шаардлагүй болох гэх мэт




Зураг 3. Бэлчээрт хотлуулах отроор бэлчээрийн ургамлыг хэнзлүүлэн ашиглах арга

Бэлчээрийн ургамлын хэнзлэх хугацаанд нь тохируулан давтан ашиглах нь олон талын ач холбогдолтой. Үүнд:


- Бэлчээрийн ургамал нөхөн сэргэх боломжтой болох,
- Ургамал хэнзлэх нөхцөл бүрдэх,
- Холын нүүдэл хийх шаардлагүй болох гэх мэт

Бэлчээрийн бүс нутаг бүрт ургамлын хэнзлэх тоо, ашиглах давтамж харилцан адилгүй байдаг.



Хангайн бүс	Хээр талын бүс	Говийн бүс
		
Хэнзлэх хоног -30-36	Хэнзлэх хоног -36-40	Хэнзлэх хоног -30-35 хуртай жил
Хэнзлэх тоо-1	Хэнзлэх тоо-2	Хэнзлэх тоо-1
Ашиглалтын давтамж-2	Ашиглалтын давтамж-3	Ашиглалтын давтамж-2

Дасгал 3. Зураг 4-ийг ашиглан, бэлчээрээ нүүдлээр ашиглах төлөвлөгөө хийгээрэй.



Зураг 4. Бэлчээрийг нүүдлээр ашиглах арга





Бэлчээрийг отроор ашиглах.

Бэлчээрийн гол нутаг талхлагдах, ган зудад нэрвэгдэн мал бэлчих боломжгүй болсон нөхцөлд бэлчээрийн ургамал сайтай хэвээр байгаа алсын соргог бэлчээрийг отроор ашигладаг.

Отрын талаар Мал сүрэг тарган тавтай юу? хэмээх (Модуль 2) модульд дэлгэрэнгүй байгаа.

Зураг 5. Хотгүй отор



Бэлчээрийг хашиж ашиглах арга. Бэлчээрийг хашиж нөөцлөх нь өвөл, хаврын тэжээлийн байнгын дутагдлыг сааруулах чухал эх үүсвэр болдог. Иймээс цөл, цөлөрхөг хээрийн бүс нутагт малчид өвөл, хаврын улиралд мал бэлчээх нутгийг ихэвчлэн дэрстэй хөндий, эсвэл алаг цоог дэрстэй газрыг сонгож хашиж нөөцөлдөг.



Зураг 6. Нөөц бэлчээрийн зориулалтаар хашсан дэрст бэлчээр

Бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлж ашиглах арга

Манай ард түмэн худаг гарган бэлчээр ашиглагдаагүй бэлчээрийг ашиглах арвин



туршлагатай. Ус гарах газрыг шинждэг олон энгийн арга байдаг. Жишээ нь:

- Нам дор газар дэрс, цахилдаг, заг, ширэг улалж элбэг ургасан байвал 2 алд орчим гүнд ус байгаагийн шинж.
- Өвөл дэрс, сондуулыг дайрч газар тоонолжин хагарсан байвал ус байгаагийн шинж
- Гүн рүү малтах тусам элсний ширхэг томорч хайрга гарч байвал ус гарахын шинж
- Газрыг тохой хиртэй ухаад шаазан аяга хөмөрч булаад маргааш нь аяганы дотор талд ус бөнжгөнөж байвал усны ундарга ойрхон байгаагийн шинж.
- Шинэ гаргасан худгийн усыг нь шавхаж орхиход усны түвшин хуучин хэмжээндээ хүрч чадахгүй бол жинхэнэ ундаргыг олоогүйн шинж
- Усыг нь шавхаад орхиход усны түвшин байсан хэмжээндээ юмуу илүү гарч байвал ундаргыг олсны шинж гэх мэт
- Газар гэссэн үед гаргасан худаг нь голдуу завсрын устай өөрөөр хэлбэл, газрын гүнээс ундаргагүй өнгөний устай худаг болдог. Ийм худгийн олонхийн ус нь хур бороо ховор болмогц ширгэж өвөл нь хөлддөг. Иймээс худгийг газар ид хөлдүү байхад арван хоёрдугаар сарын сүүлч буюу нэг, хоёрдугаар сард ухах нь ашигтай байдаг.

Эрдэмтний зөвлөгөө

Ү.Аварзэд, Т.Содной нар Хэчнээн сайхан бэлчээр байвч усгүй бол ашиглаж болдоггүй... Тэнд нэг худаг гаргахад л худгаас 5 км зайд буучихаад малаа услаад бас гэрээсээ гадагш 5 км-т малаа бэлчээхэд худгаас хааш хаашаа 10 км зайд $10 \times 10 = 100$ км² буюу 10 сая кв.м талбайн бэлчээрийг ашиглаж болдог. Бороо, цас, шар усны урсацыг тосгуулж далан, боолт хийвэл тэнд цөөрөм ус тогтож, ямар нэг хугацаагаар мал бэлчээх бололцоо гардаг.

Гол, горхи, булгийн усыг боолт хаалт хийж халиаж гаргаад хонхор хотгор дагуулж, эсвэл шуудуу хийж урсгавал бэлчээрийн талбайг томсгож ашиглаж болдог.

Усгүй бөгөөд сайхан бэлчээрт төмөр усан сан тавих буюу бетон сан хийж, ус тээвэрлэн сандаа хийгээд малаа услан бэлчээр хожиж ашиглах зэргээр бэлчээрийн даацыг урт, богино хугацаагаар нэмэгдүүлж болдог...



4.БЭЛЧЭЭР, ХАДЛАНГИЙН ТАЛБАЙГ ТОРДОЖ САЙЖРУУЛАХ АРГА



Бэлчээр доройтоход

- Тэжээлийн ургамлын зүйлийн тоо цөөрөх
- Хог ургамлын тоо нэмэгдэх
- Хагд багасах
- Халцгай газар нэмэгдэх
- Ургамлын шимт чанар буурах
- Ургац буурах зэрэг өөрчлөлтүүд гарна гэж байна, Ганаа.

-Танай бэлчээрт дээрх өөрчлөлт гарч байна уу?



-Таны сая хэлсэн өөрчлөлтүүд ажиглагдах боллоо. Бэлчээрээ жаахан тордмоор л байна.

Эрдэмтний зөвлөгөө

Ү.Аварзэд, Т.Содной нар. Цөлжилт, талхлагдал бол аль аль нь бэлчээрийн доройтол мөхөл юм. Цөлжилтийн гол шалтгаан нь байгаль цаг уурын нөлөөлөл, дулаарлын нөлөө, бэлчээрийн буруу ашиглалт юм. Харин бэлчээрийн талхлагдал бол малчин хүний буруу үйл ажиллагаа, орон нутгийн засаг захиргааны ажлын хариуцлагагүйгээс болж байна.


Тодорхой нутаг бэлчээрийг олон жил буруу аргаар, сэхэж сэргэхгүй болтол давтан нутаглах болсон. Энэ нь баг, сум бэлчээрээ зөв зохистой ашиглах төлөвлөгөө, график, зохион байгуулалт, нарийн хуваарь, журамгүй ашигласан, тухайлбал жил бүр өвс, ургамлын ургах, цэцэглэх, үрлэх цагт давтан талхалж, байнга мал бэлчээж, ургах, цэцэглэх, үрлэх бололцоогүй болгож, ялангуяа, бэлчээрт зонхилгоч нэг наст ургамалд ургах бололцоо олгохгүй болжээ.

Байгалийн бэлчээр, хадлангийн талбайг сайжруулж ургац нэмэгдүүлэхэд **тордож сайжруулах, үндсээр нь сайжруулах** гэсэн 2 үндсэн арга байдаг.



а. Тордож сайжруулах арга нь хөрсийг хагалж боловсруулахгүйгээр услах, бордох, олон наст ургамлын үр хачирлан тариалах зэргээр тэжээлийн ашигт ургамлын ургах орчинг сайжруулахаар хийж буй цогц арга хэмжээ юм.

Бордох арга. Бэлчээрийг зун ургамал ургахын өмнө эсвэл намар ургамал хагдарсаны дараа бордоно. 2-3 жил өнжсөн аргал, хомоол, хонины хөх бууцыг бэлчээрт хуурайгаар нь цацах буюу усанд хандлан жигд тараах аргаар бордоно.



Эрдэмтний зөвлөгөө


Монгол улсын ардын багш, академич, доктор, профессор Ч. Авдай. Малын өтөг, бууц, нойтон шивх, шувууны сангас, давс болон бусад шаардлагатай бодисыг хольж хийсэн бордоог шим бордоо хэмээн нэрлэдэг.

Шим бордоо нь хөрсийг тэжээллэг бодисоор хангаад зогсохгүй нүүрсхүчлийн хийгээр баяжуулж, ялзмагийг нэмэгдүүлнэ. Хонь, ямааны бууц, адууны хомоол шим бордоонд ихээхэн тохиромжтой. Тэжээл иддэг үхрийн баасаар бордоход хаягдал ургамал ургах явдал өсдөг учраас баасаа хатааж нунтаглаад дотор нь хадгалагдаж байгаа өвс, тэдгээрийн үрийг ялгаж хаях хэрэгтэй.

Усалгааны арга. Хур тунадас их ордог нутаг, гол мөрний сав дагуу нутгуудад хэрэглэдэг. Хаврын цас мөсний хайлсан ус, зуны хур бороо үерийн усыг гол мөрний адаг юм уу нам дор газраар 15-30 хоног боож, дараа нь задгай тавиад тэр хавийн бэлчээр хадлангийн талбайг усална.



Тэжээлийн ургамлын үр нэмж тариалах арга. Монгол орны нөхцөлд бэлчээрт нэмж тариалахад царгас, хошоон, ерхөг, согоовор, өлөнгө зэрэг ургамлууд тохиромжтой байдаг. Ургамлын үрийг зуны улиралд борооны өмнө эсвэл дараа нь 6-дугаар сарын 15-25-ны хооронд тарина.




Үрийг гараар цацах буюу үр гоожиж байхаар хэд хэдэн жижиг нүх бүхий уутанд хийж, түүнийгээ номхон хонь малын хүзүүнд өглөө бэлчээрт гарахад нь уяж явуулах аргаар бэлчээрт тарьж болно.



-Болороо, энэ зүгээр арга байна, хө. Чи уут хий. Хэдэн хонь маань бэлчээрээ тордоход туслах нь байна шүү дээ...

-Юугаар уут хийх вэ? Гялгар уут болох болов уу? Сумын Мал эмнэлэг, үржлийн тасаг дээр ургамлын үр зарж байгаа гэсэн шүү... Аваад тариад үзье.



6. Үндсээр нь сайжруулах аргаар тордож сайжруулах боломжгүй буюу дов сондуул ихтэй талбайг хагалж боловсруулан нэг ба олон наст ургамал тариалж таримал бэлчээр бий болгоно. Энэ аргаар бэлчээр сайжруулах ажил нь хүн хүч, техник хэрэгсэл нилээд шаардах учир малчдын бүлэг, хоршоотой хамтран ажиллах хэрэгтэй ба Мал эмнэлэг-үржлийн тасгийн мэргэжилтнүүдээс тусгай зөвлөгөө авах нь зүйтэй.




Бэлчээр ашиглах, тэжээлийн ургамал тариалахад ашиглах тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааны санамж.


Бэлчээрийг сайжруулж тордоход энгийн гар багаж хэрэгслээс эхлээд машин, трактор, бууц, бордоо, ургамлын үр, мод, чулуу зэрэг олон зүйлийг ашигладаг. Тэдгээрийг аюул, осолгүй ашиглах, ялангуяа хүүхдэддээ сайн ойлгуулах, болгоомжлуулах талаар анхаарч байгаарай. Үүнд:



- Бэлчээртээ тарихаар авсан ургамлын үрийг хүүхэд амандаа хийж, амсаж үзэхгүй байхыг сануулаарай.
- Элдэв бордоо хэрэглэхдээ хамгаалалтын бээлий, амны хаалт хэрэглэж, ам, хамар, нүд рүү орохоос сэргийлээрэй.
- Машин техник ашиглах бол бүрэн бүтэн байдлыг нь сайтар шалгаж байгаарай. Шатах тослох материалаа горимын дагуу хадгалж, гал алдахаас болгоомжлоорой.
- Бууц нь үнэгүй бэлэн бордоо. Тэгэхлээ зөв ашиглахгүй бол хогийн ургамалыг нэмэгдүүлэх муу талтай. Бууцыг намар, өвлийн улиралд цуглуулан овоолж нэг 1-2 жил өнжөөж хог, ургамлын үрийг цэвэрлэж бэлчээр, таримал ургамлыг бордоно.



- Ургамлынхаа үрийг тусгай уут саванд хийж хаяглан, хольж, хутгахааргүй хадгалаад, зааврын дагуу ашиглаарай.
- Мод, чулуу ашиглаж хаалт далан барих, худаг гаргах зэрэгт чулуу нурах, гар, хөлөө гэмтээх, шархтуулахаас сэргийлээрэй. Эдгээр анхаарал болгоомж шаардсан ажилд насанд хүрээгүй хүүхдийг оролцуулахгүй байх нь дээр.



- Хүрз жоотуу, алх сүх, хөрөө зэрэг багаж хэрэгслийг анхаарал болгоомжтой ашиглан, ажлаа дууссаны дараа хүүхэд хүрэхээргүй газарт хадгалж занших нь энгийн боловч хэрэгжүүлэхээр зүйл юм. Жишээлбэл, өвлийн хүйтэнд гадаа цантсан сүх, хүрз мэтийн төмөр хэрэгслийн цанг сонирхон долоож хэлээ наалдуулсан хүүхэд зөндөө л байдаг шүү дээ.

-За одоо хоёулаа юу сурч, сурснаа хэр зэрэг хэрэгжүүлж байгаагаа хамтран үнэлье.

-Нөхөр даргад, Ганаа хүү шалгуулахад бэлэн байгаагаа мэдэгдье!



-Эхлээд тэмдэглэлийн дэвтэр ургамлын цуглуулгаа үзүүлдээ.

-Болж байна, хө. "5" оноо өглөө.

Адиа Ганаа хоёр асуулт бүрээр Ганаад оноо өгч, нэгтгэн дүгнэв. Ганаа 86 оноо авсан болохоор Адиа "Сурсан зүйлээ сайн хэрэгжүүлж байна" гэсэн үнэлгээ өгөв.





ҮНЭЛГЭЭНИЙ ХҮСНЭГТ

(сайн- 4 оноо, дутуу- 2 оноо, муу- 0 оноо)

Д/д	Үнэлэх үзүүлэлт	Хэрэгжүүлсэн байдал			Нийт оноо
		Сайн	Дутуу	Муу	
1	Тэмдэглэлийн дэвтрийн баяжуулалт	5			5
2	Тэмдэглэсэн мэдээллийг эргэн санаж байгаа эсэх		3		3
3	Ургамлын цуглуулга байгаа эсэх	5			5
4	Цуглуулга дахь ургамлыг таньж, тайлбарлаж байгаа байдал	5			5
5	Бэлчээрийн ургамлыг тодорхойлж чадах эсэх	5			5
6	Бэлчээрийнхээ талбайг тодорхойлж чадах эсэх	5			5
7	Малаа хонин толгойд шилжүүлж чадах эсэх	5			5
8	Бэлчээрийн даацыг тодорхойлж чадах эсэх		3		3
9	Бэлчээрийнхээ ургамлын хэнзлэх хугацааг ажигласан эсэх	5			5
10	Ургамал хэнзэлсэн үед бэлчээрээ давтан ашигласан эсэх	5			5



11	Сэлгээний нарийвчилсан бүдүүвч гаргасан эсэх	5			5
12	Бэлчээрийг сэлгэж ашигласан эсэх	5			5
13	Бэлчээрээ бордох талаар төлөвлөж байгаа ажил байгаа эсэх	5			5
14	Бэлчээртээ олон наст ургамлын үр цацах төлөвлөгөө байгаа эсэх	5			5
15	Бэлчээрийн уст цэгийг энгийн аргаар тогтоох арга мэдэж байгаа эсэх	5			5
16	Бэлчээртээ худаг гаргаж эсвэл засаж ашигласан эсэх				0
17	Бэлчээрийг хашиж ашиглах төлөвлөгөө боловсруулсан эсэх	5			5
18	Бэлчээрийг хашиж ашиглах газраа сонгосон эсэх	5			5
19	Бэлчээрийг хашиж ашиглаж байгаа эсэх			0	0
20	Дараагийн модулиар суралцах хүсэлтэй байгаа эсэх	5			5
Үнэлгээний дүн, оноогоор		80	6		86

Тайлбар:

Үнэлгээний хугацаанд амжаагүй ажлаа хийж гүйцэтгэсний дараа дахин үнэлүүлж тооцуулж болно.

Нийт онооны:

80-100% Сурсан зүйлээ сайн хэрэгжүүлж байна.

70-89% Хэрэгжүүлэх эхлэл санаачилга байна.

60-79% Хэрэгжүүлэх оролдлого байгаа боловч тодорхой амжилт гараагүй байна.

60%-аас бага бол хэрэгжүүлээгүй.



Ганаа “Сурсан зүйлээ сайн хэрэгжүүлж байна” гэсэн үнэлгээ аваад, дуугаа дуулан гэрийн зүг одов. Адиа шавийнхаа амжилтад баярлан их л урамтай үлдэв.

Шилийн задгай нутаг минь
Шимтэй ургамлаар арвин юм
...



Монгол улсын хөдөлмөрийн баатар,
ардын уран зохиолч Л. Түдэв


“МАЛЧИН Ө-ГИЙНД НОЁН Ө ЗОЧЛОВ” БАРИМТАТ ТУУЖААС

...-Манаг гэнэ үү? тэр чинь юу гэсэн үг вэ гэж асуув.

-Энийг хэлж байгаа юм. Манаг биш манхаг! Янз бүрийн эмийн ургамал түүж хийгээд хадгалдаг сав л даа.

-Өө яасан сонин юм бэ? Би үзэж болох уу? гээд Өупэншоу ноён ухасхийн нөгөөх илгэн манхагны өнцгөөс атган авав. Дүгрэг хэлбэртэй, сархинаг шиг олон хуниастай, зөөлхөн торго шиг элдмэл хөмөн сав ажээ. Хуниас болгон нь тусгаарлагдсан уут бөгөөд тус бүрд нь ямар нэгэн үр, ургамал, навч, үндэс мэтийн зүйл хийжээ.

Маш содон үнэр ханхалж байв. Амыг нь хүвэрхий суран уяагаар бөхөлжээ. Нэг үзүүрээс нь татахад бүх уутнууд нь хунигдан эвхэгдээд чимхсэн бууз шиг хэлбэртэй бөмбөгөр юм болчихдог тэр манхгийг Өупэншоу нэг бүрчлэн үзэж



юу юу байгааг нь асуух хүсэл төржээ. Өүпэншоу

-Энэ юу вэ? гэж эхний уутан дахь жижигхэн цагаан цэцгийн дэлбээ шиг юмыг заав.

-**Далийн цэцэг.** Биеийг шимжүүлж, нас уртасгахад хэрэг болдог. Бас хүйтэн сэрүүн өвчнийг арилгана гэж Өлзийбуянт тайлбарлав.

-Сайхан үнэртэй юм. Нас уртасгана гэнээ гэж Өөп ноён амандаа бувтнан дараах уутнаас цухуйх бөөрөнхий цагаан толгойтой цэцэгт ургамлыг зааж

-Энэ юу вэ? гэхэд

-**Чөдөр өвс гэдэг юм.** Илч үүсгэдэг, бэтэг өвчнийг задалдаг, нян бадгана өвчнийг зогсоодог гэхэд дараах уутан дах өргөслөг улаавтар ургамлыг зааж

-Энэ юу вэ? гэв.

-**Цулхир гэдэг юм.** Өвчин бүгдэд тустай. Хижиг, хорын болон бөөрний халуунд сайн. Бас гурил хийдэг. Тэр нь тусдаа бий.

-Энэ юу вэ?

-**Алтан гагнуур.** Шархыг барилдуулж, хорын халууныг эмчилдэг.

-Энэ юу вэ?

-**Зээргэнэ.** Цус зогсоох, элэгний халууныг дарах, хавдрыг намтгахад хэрэгтэй.

-Энэ юу вэ?

-**Халгай.** Илчийг үүсгэнэ, хийг дарна. Хуучин халууныг намжаана.

-Энэ юу вэ?

-**Цахилдаг.** Өвчин бүгдийг хөөж гаргана. Шар өвчин, ходоодны бадгана, хорын өвчинд сайн.

-Энэ юу вэ?

-**Царван.** Хоолойн халуун, уушгины өвчинд сайн.

-Энэ юу вэ?

-**Бэрээмэг.** Цусны өвчин анагаадаг юм.

-Энэ юу вэ?

-**Ажигцэрэн.** Яс хугарсныг барилдуулж өгнө.

-Энэ юу вэ?

-**Гич.** Боом өвчнийг анагаана.

-Энэ юу вэ?

-**Шимтэглэй.** Нүдний өвчин анагаадаг.



-Энэ юу вэ?

-**Юмдүүжин.** Умайн өвчнийг анагаадаг.

-Энэ юу вэ?

-**Чихэр өвс.** Уушги, судасны өвчнийг анагаана.

-Энэ юу вэ?

-**Тарна.** Халуун өвчнийг туулгана.

-Энэ юу вэ?

-**Зангуу.** Шижин өвчнийг бас бөөрний өвчинг эдгээнэ.

-Энэ юу вэ?

-**Гишүүнэ.** Хор, халуун ер нь өвчин бүхнийг туулгана.

-Энэ юу вэ?

-**Хусны цэцэг.** Идээ, бээр, муу цусыг хатаана.

-Энэ юу вэ?

-**Чачаргана.** Уушги цоорох, цус бүлэгнэхийг зогсоох, бадганыг арилгах шидтэй.

-Энэ юу вэ?

-**Заг мод.** Тарваган тахал тусахаас хамгаална...

5, АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Аварзэд Ү., Содной Т., **“Монголын нүүдлийн соёл иргэншил бэлчээрийн мал аж ахуй”** УБ., 2011
2. Минжигдорж Б., Найданхүү М., Наранцэцэг Г., **“Буянт мал”** (Малчдад зориулсан гарын авлага, Дэлхийн зөн Олон улсын байгууллагын Монгол дахь салбар, 2001)
3. Түдэв Л., **“Малчин Ө-гийнд ноён Ө зочлов”** УБ., 2009
4. **Үндэсний нэвтэрхий толь.** Үндэсний цахим өв академи, 2011



ХӨДӨӨ АЖ АХУЙН
ҮЙЛДВЭРЛЭЛД
ШИНЖЛЭХ
УХААНЫ ОЛОЛТ
НЭВТРҮҮЛЭХ ТӨВ

Монгол Улс
Улаанбаатар хот-15141
Чингэлтэй дүүрэг #60/1 байр
Утас/факс: 976 70118087
Вэб сайт: <http://www.naec.mn>
И-мэйл: info@naec.mn

ОЛОН УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН
БАЙГУУЛЛАГА

НҮБ-ын байр, Өрөө 209
Нэгдсэн үндэстний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14201,
Монгол Улс
Утас: 976 11 320624
Факс: 976 11 320625
<http://www.ilo.org>
